



НИЙСЛЭЛИЙН АГААРЫН ЧАНАРЫН
АЛБАНЫ ДАРГЫН ТУШААЛ

2011 оны 04 сарын 29 өдөр

Дугаар 16

Улаанбаатар хот

Ажил хавсруулан гүйцэтгүүлэх
тухай

Нийслэлийн Засаг Даргын Тамгын газрын 2009 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн 3/153 дугаар албан тоот, Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 17.1 дүгээр заалтыг үндэслэн ТУШААХ НЬ:

Нэг. Хүний нөөц, хууль, эрх зүйн асуудал хариуцсан мэргэжилтэн Б.Сүхбаатар нь хүний нөөц, хууль эрх зүй, УИХ, Засгийн газар, НИТХ-ын тогтоол шийдвэр, Нийслэлийн Засаг даргын захирамжийн биелэлт, тус байгууллагын төрийн албан тушаалтнуудын хөрөнгө, орлогын мэдүүлгийг бүртгэх, хадгалах ажил үүргийг хавсран гүйцэтгэдэг тул ажлын ачааллыг харгалзан үзэж ажил үүрэг хавсран гүйцэтгэсний нэмэгдэлийг үндсэн цалингийн хорин хувиар олгосугай.

Хоёр. Ажил үүрэг хавсран гүйцэтгэсний нэмэгдлийг 2011 оны 05 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн Б.Сүхбаатарт сарын үндсэн цалингийн 20 хувиар бодож олгохыг ня-бо /П.Ариунаа/-д зөвшөөрсүгэй.

Гурав. Энэхүү тушаал гарч мөрдөгдөх болсонтой холбогдуулан 2009 оны 07 дугаар сарын 06-ны өдрийн 25 тоот тушаалыг хүчингүйд тооцсугай.

ДАРГА



Д. МӨНХЦОГ